



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/5/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ХОНГОР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Ч.МӨНХТУЯА ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 46
танай 2025.07.23 -ны № 2/52 -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хонгор сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 2,424,668.1 мянган төгрөгийн хөрөнгө бий болж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 79.8 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хонгор сумын ЗДТГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Хонгор сумын ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний багаас 98.9 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4525020047³

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>377,873,245.00</u>	<u>641,484,481.87</u>
33	АВЛАГА	1,292,500.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,292,500.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	376,580,745.00	641,484,481.87
354	Хангамжийн материал	261,880,745.00	359,549,481.87
35410	Бичиг хэргийн материал	2,422,000.00	1,691,500.00
35420	Аж ахуйн материал	5,512,400.00	72,013,014.60
35440	Түлш, шатах тослох материал	5,270,000.00	11,237,170.00
35470	Бусад хангамжийн материал	248,676,345.00	274,607,797.27
35500	Биологийн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
35600	Мал амьтад	94,700,000.00	261,935,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,270,035,219.86</u>	<u>10,721,330,830.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,270,035,219.86	10,721,330,830.37
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	8,140,222,639.86	9,452,963,110.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,784,288,290.99	2,870,371,909.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(761,433,687.31)	(897,758,819.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	569,721,800.00	288,789,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(303,808,366.47)	(181,276,153.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	380,003,970.99	329,984,160.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(141,429,275.58)	(138,588,808.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	178,675,044.00	179,705,380.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,655,525.02)	(70,447,710.02)
39209	Зам, гүүрийн байгууламж	5,513,404,699.00	6,712,454,760.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(595,976,057.93)	(1,161,810,593.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	746,321,526.86	1,893,393,062.54
39215	Хуримтлагдсан элэгдэл	(180,889,779.67)	(371,853,877.06)
393	Биет бус хөрөнгө	1,129,812,580.00	1,268,367,720.00
39301	Программ хангамж	824,580.00	824,580.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(274,860.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,128,988,000.00	1,267,818,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,647,908,464.86</u>	<u>11,362,815,312.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,647,908,464.86</u>	<u>11,362,815,312.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,647,908,464.86	11,362,815,312.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,290,405,055.17	2,429,235,055.17
51101	Өмч: - төрийн	2,290,405,055.17	2,429,235,055.17
512	Хуримтлагдсан үр дүн	6,710,632,779.63	8,286,709,627.01

51210	Өмнөх үеийн үр дүн	6,710,632,779.63	6,710,632,779.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,576,076,847.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	646,870,630.06	646,870,630.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,647,908,464.86</u>	<u>11,362,815,312.24</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,009,726,297.09	5,945,343,794.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	791,919,247.09	2,796,143,854.49
120	Нийтлэг татварын бус орлого	791,919,247.09	2,796,143,854.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,397,300.00	24,311,298.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,397,300.00	24,311,298.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	685,131,947.09	2,466,647,179.62
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	84,395,000.00	305,185,376.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,217,802,050.00	3,149,199,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,183,650.00	31,609,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,979,950.00	31,609,340.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,203,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,206,618,400.00	3,117,590,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,206,618,400.00	3,117,590,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,197,030,804.89	4,185,120,667.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,197,030,804.89	4,185,120,667.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,133,551,482.88	3,189,498,393.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	623,541,366.24	1,121,050,364.67
210101	Үндсэн цалин	320,311,604.89	436,563,566.37
210102	Нэмэгдэл	184,628,567.00	550,268,998.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,060,651.00	70,430,000.00
210104	Урамшуулал	37,791,144.00	63,787,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	58,749,399.35	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,398,700.00	139,237,131.35
210201	Тэтгэврийн даатгал	53,340,300.00	91,957,231.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,400.00	12,139,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,130,200.00	6,057,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,254,900.00	4,950,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,543,900.00	24,132,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,848,153.84	211,001,686.78
210301	Гэрэл, цахилгаан	29,462,779.84	34,766,165.78

ХТ05430 @ 9022899

210302	Түлш, халаалт	102,629,703.00	171,837,408.00
210303	Цэвэр, бохир ус	6,755,671.00	4,398,113.00
2104	Хангамж, бараа материалын зардал	104,371,055.36	141,356,896.05
210401	Бичиг хэрэг	13,410,120.00	13,850,700.00
210402	Тээвэр, шатахуун	68,662,506.00	85,612,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,638,925.36	6,007,476.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,659,504.00	35,886,410.00
2105	Нормативт зардал	1,295,000.00	2,380,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,295,000.00	2,380,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,271,390.00	49,237,944.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	422,300.00	3,821,000.00
210604	Урсгал засвар	32,849,090.00	45,416,944.00
2107	Томилолт, зочны зардал	7,632,000.00	10,470,000.00
210702	Дотоод албан томилолт	7,632,000.00	10,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,413,248.55	138,385,081.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,785,108.55	136,842,585.00
210803	Даатгалын үйлчилгээ	449,802.00	770,310.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	437,338.00	541,186.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	543,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,091,780,568.89	1,376,379,289.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,967,543.45	347,893,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,300,000.00	4,590,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	972,513,025.44	1,023,895,969.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,479,322.01	995,622,274.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,901,500.00	75,391,278.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,480,000.00	2,990,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,497,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	55,061,278.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,924,000.00	4,470,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,577,822.01	920,230,995.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,504,122.01	920,080,995.65
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	73,700.00	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(187,304,507.80)	1,760,223,126.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	737,002,814.68	184,146,279.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	737,002,814.68	184,146,279.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(737,002,814.68)	(184,146,279.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(924,307,322.48)	1,576,076,847.38

ХТ05430 @ 9922899

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,279,154,805.45</u>	<u>3,173,511,238.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,397,300.00	24,311,298.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,397,300.00	24,311,298.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,397,300.00	24,311,298.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,397,300.00	24,311,298.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,256,757,505.45</u>	<u>3,149,199,940.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,139,105.45	31,609,340.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,935,405.45	31,609,340.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,203,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,206,618,400.00	3,117,590,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,206,618,400.00	3,117,590,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,241,175,105.45</u>	<u>3,119,650,558.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,241,175,105.45</u>	<u>3,119,650,558.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,177,343,783.44</u>	<u>2,124,028,283.85</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	624,833,866.24	1,119,757,864.67
210101	Үндсэн цалин	321,604,104.89	435,271,066.37
210102	Нэмэгдэл	184,628,567.00	550,268,998.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,060,651.00	70,430,000.00
210104	Урамшуулал	37,791,144.00	63,787,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	58,749,399.35	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,398,700.00	139,237,131.35
210201	Тэтгэврийн даатгал	53,340,300.00	91,957,231.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,272,400.00	12,139,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,987,200.00	6,057,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,254,900.00	4,950,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,543,900.00	24,132,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,848,153.84	211,001,686.78
210301	Гэрэл, цахилгаан	29,462,779.84	34,766,165.78
210302	Түлш, халаалт	102,629,703.00	171,837,408.00
210303	Цэвэр, бохир ус	6,755,671.00	4,398,113.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,763,881.36	110,853,716.05
210401	Бичиг хэрэг	13,118,550.00	13,060,200.00
210402	Тээвэр, шатахуун	69,892,506.00	85,142,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,638,925.36	6,007,476.05

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,113,900.00	6,643,400.00
2105	Нормативт зардал	1,295,000.00	2,380,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,295,000.00	2,380,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,077,390.00	68,436,644.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,452,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,291,800.00	11,661,000.00
210604	Урсгал засвар	37,785,590.00	55,323,144.00
2107	Томилолт, зочны зардал	7,632,000.00	10,470,000.00
210702	Дотоод албан томилолт	7,632,000.00	10,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,863,248.55	150,565,081.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,235,108.55	149,022,585.00
210803	Даатгалын үйлчилгээ	449,802.00	770,310.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	437,338.00	541,186.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	543,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,631,543.45	311,326,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,331,543.45	306,736,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,300,000.00	4,590,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,831,322.01	995,622,274.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,253,500.00	75,391,278.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,832,000.00	2,990,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,497,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	55,061,278.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,924,000.00	4,470,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,577,822.01	920,230,995.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,504,122.01	920,080,995.65
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	73,700.00	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,979,700.00</u>	<u>53,860,680.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,979,700.00	53,860,680.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,979,700.00	53,860,680.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,979,700.00	53,860,680.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,979,700.00	53,860,680.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(37,979,700.00)</u>	<u>(53,860,680.00)</u>


ХТ05439 @ 9022899

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,290,405,055.17	646,870,630.06	7,634,940,102.11	10,572,215,787.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,290,405,055.17	646,870,630.06	7,634,940,102.11	10,572,215,787.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(924,307,322.48)	(924,307,322.48)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,290,405,055.17	646,870,630.06	6,710,632,779.63	9,647,908,464.86
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,290,405,055.17	646,870,630.06	6,710,632,779.63	9,647,908,464.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,290,405,055.17	646,870,630.06	6,710,632,779.63	9,647,908,464.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	138,830,000.00	-	-	138,830,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,576,076,847.38	1,576,076,847.38
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,429,235,055.17	646,870,630.06	8,286,709,627.01	11,362,815,312.24



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,139,506,200.00	2,221,820,902.35	(917,685,297.65)	70.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,647,506,200.00	2,221,820,902.35	(425,685,297.65)	83.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,570,634,200.00	2,146,429,623.85	(424,204,576.15)	83.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,962,800.00	1,118,277,864.67	(135,684,935.33)	89.2
210101	Үндсэн цалин	462,448,500.00	435,271,066.37	(27,177,433.63)	94.1
210102	Нэмэгдэл	629,852,300.00	550,268,998.30	(79,583,301.70)	87.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,600,000.00	70,430,000.00	(17,170,000.00)	80.4
210104	Урамшуулал	74,062,000.00	62,307,800.00	(11,754,200.00)	84.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,745,600.00	139,237,131.35	(17,508,468.65)	88.8
210201	Тэтгэврийн даатгал	106,587,100.00	91,957,231.35	(14,629,868.65)	86.3
210202	Тэтгэмжийн даатгал	12,539,600.00	12,139,600.00	(400,000.00)	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,269,800.00	6,057,300.00	(212,500.00)	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	6,269,800.00	4,950,900.00	(1,318,900.00)	79.0
210205	Эрүүл мэндийн даатгал	25,079,300.00	24,132,100.00	(947,200.00)	96.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,720,900.00	211,001,686.78	(33,719,213.22)	86.2
210301	Гэрэл, цахилгаан	55,320,900.00	34,766,165.78	(20,554,734.22)	62.8
210302	Түлш, халаалт	182,400,000.00	171,837,408.00	(10,562,592.00)	94.2
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	4,398,113.00	(2,601,887.00)	62.8
2104	Хангамж, бараа материалын зардал	100,097,100.00	100,196,376.05	99,276.05	100.1
210401	Бичиг хэрэг	14,090,000.00	13,010,200.00	(1,079,800.00)	92.3
210402	Тээвэр, шатахуун	74,448,100.00	74,535,300.00	87,200.00	100.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,759,000.00	6,007,476.05	1,248,476.05	126.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,800,000.00	6,643,400.00	(156,600.00)	97.7
2105	Нормативт зардал	2,406,700.00	2,380,000.00	(26,700.00)	98.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,406,700.00	2,380,000.00	(26,700.00)	98.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,281,500.00	71,604,044.00	(677,456.00)	99.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,023,000.00	11,012,000.00	(11,000.00)	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,342,900.00	1,339,000.00	(3,900.00)	99.7
210604	Урсгал засвар	59,915,600.00	59,253,044.00	(662,556.00)	98.9
2107	Томилолт, зочны зардал	12,411,000.00	10,470,000.00	(1,941,000.00)	84.4
210702	Дотоод албан томилолт	12,411,000.00	10,470,000.00	(1,941,000.00)	84.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,456,600.00	166,936,361.00	479,761.00	100.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,305,600.00	165,393,865.00	2,088,265.00	101.3
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	770,310.00	(229,690.00)	77.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	580,000.00	541,186.00	(38,814.00)	93.3


210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,000.00	231,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00		(720,000.00)	0.0
210807	Газрын төлбөр	572,000.00		(572,000.00)	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,000.00		(48,000.00)	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	561,552,000.00	326,326,160.00	(235,225,840.00)	58.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	553,500,000.00	321,736,160.00	(231,763,840.00)	58.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,052,000.00	4,590,000.00	(3,462,000.00)	57.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,872,000.00	75,391,278.50	(1,480,721.50)	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,872,000.00	75,391,278.50	(1,480,721.50)	98.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,990,000.00	(10,000.00)	99.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	56,502,000.00	55,061,278.50	(1,440,721.50)	97.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	4,470,000.00	(30,000.00)	99.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	492,000,000.00	-	(492,000,000.00)	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	492,000,000.00	-	(492,000,000.00)	0.0
223001	Бусад хөрөнгө	492,000,000.00	-	(492,000,000.00)	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,139,506,200.00	2,221,820,902.35	(915,289,599.65)	70.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,117,590,600.00	2,197,509,604.35	(917,685,297.65)	70.5
132001	Орон нутгийн төсвөөс	3,117,590,600.00	2,197,509,604.35	(917,685,297.65)	70.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,915,600.00	24,311,298.00	2,395,698.00	110.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,915,600.00	24,311,298.00	2,395,698.00	110.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00	34.00		
620001	Удирдах ажилтан	3.00	3.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	29.00		
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		

ХТ05430@9022899

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,459,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,459,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,459,340.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,480,000.00
210104	Урамшуулал	1,480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,657,340.00
210401	Бичиг хэрэг	50,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,607,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,322,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,322,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,459,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,459,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,459,340.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын ЗДТГ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа явуулдаг, Хонгор сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус сум 2024 оныг *"Иргэдийн зохистой суурьшил, оршин суух таатай нөхцөлийг бүрдүүлсэн, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, дэвшилтэт эко сум болгон хөгжүүлэх"* жил болгон зарлаж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хонгор сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хонгор сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,714,906.8 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,292.5	-	(1,292.5)
Бараа материал	376,580.8	641,484.5	264,903.7
Үндсэн хөрөнгө	9,270,035.2	10,721,330.8	1,451,295.6
Нийт хөрөнгө	9,647,908.5	11,362,815.3	1,714,906.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,647,908.5	11,362,815.3	1,714,906.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,647,908.5	11,362,815.3	1,714,906.8

Өнгөрсөн онд 2 албан хаагчийн цалинг зөрүүтэй тооцсоноос үүссэн 1,292.5 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулснаар авлагын данс үлдэгдэлгүй болсон байна.

Бараа материалын өсөлтөд Дархан-Уул аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн ЗДТГ-аас 124,400.0 мянган төгрөгийн 79 толгой үхэр сүргийг шилжүүлсэн, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 114,368.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн нь голлон нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдлийн 40.8 хувийг мал амьтад эзэлж байна.

Үндсэн хөрөнгө данс 1,451,295.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ЗДТГ-ын II байрны урсгал засварын 18,929.9 мянган төгрөг, мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлсэн "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ын конторын барилгын сантехникийн засварын 18,491.3 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 3 худгийн засварын 28,662.4 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын хүрээнд "Монрок" ХХК-ний гүйцэтгэсэн сумын халуун усны барилгын засварын 20,000.0 мянган төгрөг, нийт 86,083.6 мянган төгрөгөөр барилга байгууламжийг капиталжуулж, төсвийн хөрөнгөөр 16,439.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, хандиваар ирсэн 1,150.0 мянга, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн 2,369,005.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авч, 13,320.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлүүлж, 95,568.9 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,714,906.8 мянган төгрөгөөр өссөн нь 138,830.0 мянган төгрөгийн газрыг бүртгэлд авч, 2,771,832.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,802,788.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 410,358.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,213,146.1 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд батлагдсан төсвийг 4 дүгээр сард 35,700.3 мянган төгрөгөөр, 11 дүгээр сард 890,659.8 мянган төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор хөдөө, орон

нутагт тогтвор суурьшилттай ажилласны урамшууллыг олгохоор болсон, 11 дүгээр сарын тодотголоор бараа үйлчилгээний зардалд 355,000.0 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардалд 492,000.0 мянган төгрөг тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,139,506.2 мянган төгрөг баталснаас 3,117,590.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21,915.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,117,590.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, үйл ажиллагаанаас 24,311.3 мянган төгрөгийн орлого олсноос 2,221,820.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 917,685.3 мянган төгрөг, төлөвлөгөөнөөс давсан 2,395.7 мянган төгрөг, нийт 920,081.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,221,820.9 мянган төгрөг буюу 70.8 хувьтай байгаа нь ажилчдын орон тоо дутуугаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 153,193.4 мянган төгрөгийг, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх 12 төсөл арга хэмжээг дараа онд шилжүүлснээс бараа үйлчилгээний бусад зардлаас 231,763.8 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй, мөн 3 төсөл арга хэмжээний тендерийг тайлант оны 12 дугаар сард зарласнаас 492,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авалт хийгээгүйгээс голлон шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх удирдлага	3,139,506.2	2,221,820.9	(917,685.3)	70.8
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,314,918.1	1,176,019.8	(138,898.3)	89.4
1.2	80106-Баг хоорондын үйл ажиллагааны зардал	391,954.6	369,866.9	(22,087.7)	94.4
1.3	80111-Төрийн өмчийн тогтмол зардал	304,636.5	270,254.8	(34,381.7)	88.7
1.4	80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	625.0	-	(625.0)	-
1.5	80233-Хүүхэд хамгаалал	15,000.0	14,590.0	(410.0)	97.3
1.6	80802-Ажил олгогчоос тэтгэмж урамшуулал	64,002.0	62,521.3	(1,480.7)	97.7
1.7	80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөхөн олговор	12,870.0	12,870.0	-	100.0
1.8	80918-Бусад хөрөнгө	492,000.0	-	(492,000.0)	-
1.9	81102-Орон нутгийн нөөц сан	120,000.0	116,768.8	(3,231.2)	97.3
1.10	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	400,000.0	175,465.4	(224,534.6)	43.9
1.11	81549-Ахмадын сан	8,500.0	8,497.8	(2.2)	100.0
1.12	82801-Улсын их баяр наадам	15,000.0	14,966.1	(33.9)	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тус байгууллага Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу батлагдсан төсвөөс цалингийн сангийн 0.7 хувиар буюу 8,500.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлэн, 8,498.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 166,456.6 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 166,936.4 мянган төгрөг зарцуулсан бол бараа үйлчилгээний бусад зардлаар 553,500.0 мянган төгрөг төлөвлөж, 321,736.2 мянган төгрөг зарцуулсан нь Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх 12 төсөл арга хэмжээг дараа онд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Тус байгууллага тайлант онд 37 орон тоотой ажиллахаас сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, нийгмийн бодлогын мэргэжилтний 3 орон тоо дутуу ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хонгор сумын нэмэлт санхүүжилтийн дансанд Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас үлийн цагаан оготноос урьдчилан сэргийлэх зардалд 29,100.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 2,509.3 мянган төгрөг, нийт 31,690.6 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулан, үлийн цагаан оготноос урьдчилан сэргийлэх зардлаас 150.0 мянган төгрөгийг зарцуулаагүй учир төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

3.5.5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага тайлант оны эхэнд харьцуулалтын аргаар 1 төсөл арга хэмжээний 74,448.1 мянган төгрөгийн шатахуун худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр уг арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулж, гэрээ байгуулан, хэрэгжүүлсэн байна.

Харин Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 8 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийн, хөрөнгийн зардлыг нэмэгдүүлснээр 400,000.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 92,000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар болсон байна.

Иймд дээрх 3 төсөл арга хэмжээний тендерийг тайлант оны 12 дугаар сард зарласан бөгөөд тайлант онд худалдан авах ажиллагаа явагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хонгор сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хонгор сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2/52 тоот албан бичгээр 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 3,139,506.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 47,092.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 33,719.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаcт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,538,837.5 мянган төгрөгийн 10 гүйлгээ, зарлагын 18,700.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 56,973.0 мянган төгрөгийн 26 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасны дагуу дээрх мэдээллийг нөхөж байршуулахаар, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 279.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 279.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, эзэмшлийн газрыг бүртгэлд тусгах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	279.8	1	279.8	100.0
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Нийт дүн	2	279.8	2	279.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хонгор сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 8 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийн, 492,000.0 мянган төгрөгөөр хөрөнгийн зардлыг нэмэгдүүлж, 12 дугаар сард тендер зарласан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасантай нийцэхгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 1,182,317.9 мянган төгрөгийн 3 алдааг¹ аудитын явцад залруулав. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн сумын төвийн гэрэлтүүлгийг 21,212.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, сумын төвийн хатуу хучилттай 842,632.5 мянган төгрөгийн автозам, Салхит багийн 298,469.8 мянган төгрөгийн автозамыг ангилал буруу бүртгэсэн нь УСНББОУС1, УСНББОУС17, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, “Толилуулга”, “Ангилал” батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байгаа тул илүү бүртгэсэн гэрэлтүүлгийн дүнг үндсэн хөрөнгөөс хасаж, авто замыг “Зам гүүрийн байгууламж” дансанд бүртгүүлж,
2. Мал үржүүлгийн өнгөт эхо аппаратыг 12,600.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь УСНББОУС1, УСНББОУС17, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, “Толилуулга” батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байгаа тул тус үндсэн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж,
3. Бусдад шилжүүлсэн хөрөнгийн 7,403.3 мянган төгрөгийн гарзыг “биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал”-аар бүртгэсэн нь УСНББОУС 1, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

нягтлан бодох бүртгэлийн журам”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд “биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал”-ыг бууруулж, “үндсэн хөрөнгө худалдсаны гарз” дансыг нэмэгдүүлж тус тус залруулав.

Мөн аудитаар илэрсэн 7,632.1 мянган төгрөгийн зөрчил²-д 4,658.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 2,974.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын “Шунхлай Петролиум” ХХК-тай байгуулсан гэрээний 4.4-т заасан үнийн дүнгийн 3 хувийн урамшуулал болох 3,145.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т *“төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.2-т *“санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ... бүх орлого,”* гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцсоноос 18 ажилтанд 1,513.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Байгууллагын санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 2,974.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д *“Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж”* заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Шилэн данстай холбоотой зөвлөмжийг тайлангийн 4.4.1 дэх хэсэгт тусгасан болно.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн гэрэлтүүлгийн ажлыг илүү бүртгэж, замын ажлыг ангилал буруу бүртгэсэн.	1	1,162,314.6			1	1,162,314.6	1	1,162,314.6	-	-	-	-
Хөрөнгийн өртгийг дутуу бүртгэсэн.	1	12,600.0			1	12,600.0	1	12,600.0				
Зардлыг ангилал буруу бүртгэсэн.	1	7,403.3			1	7,403.3	1	7,403.3				
Дүн	3	1,182,317.9			3	1,182,317.9	3	1,182,317.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллыг илүү олгосон.	1	1,513.1	1	1,513.1	-	-	-	-	-	-	-	-
Шатахууны урамшууллыг бүртгэж, тайлагнаагүй.	1	3,145.0	1	3,145.0	-	-	-	-	-	-	-	-
Санхүүгийн ажилтнуудад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон.	1	2,974.0	-	-	1	2,974.0	-	-	-	-	-	-
Дүн	3	7,632.1	2	4,658.1	1	2,974.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10, зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 26 тушаал, шийдвэр мэдээлээгүй.	1	2,614,510.5	-	-	-	-	1	2,614,510.5
Дүн	1	2,614,510.5	-	-	-	-	1	2,614,510.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	2,614,510.5	-	-	-	-	1	2,614,510.5